



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/201

Хэрлэн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7, 27 дугаар зүйлийн 27.1, 27.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/205 дугаар тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 222 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам"-ын нэгдүгээр хавсралт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрийн жагсаалт батлах тухай" 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.5.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Дадал сумын Балж багийн нутагт орших Нүцгэн-Өндөр уулын дурсгалт газар малтлага, судалгаа явуулахад зориулж 7 662 000 /долоон сая зургаан зуун жаран хоёр мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т үүрэг болгосугай.

4. Нүцгэн-Өндөр уулын дурсгалт газарт явуулах хээрийн судалгааг "Монгол Улсын нутагт археологи, палеонтологийн хайгуул, малтлага, судалгаа хийх журам"-ын дагуу хийж гүйцэтгэхийг Шинжлэх ухааны академийн Түүх археологийн хүрээлэн, аймгийн Музейн хамтарсан судалгааны ангийн удирдагч /Б.Цогтбаатар/-д, судалгааны ажлын тайлан мэдээг аймгийн Засаг даргад танилцуулахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

01 984

Аймгийн Засаг даргын 2017 оны
05 дугаар сарын 25 өдрийн 4/20
дугаар захирамжийн хавсралт

Нүцгэн-Өндөр уулын дурсгалт газар явуулах хээрийн судалгааны төсвийн задаргаа

Цалингийн зардал

№	Цалингийн утга	Хугацаа	Нэг өдрийн томилолт	Нийт
1	Удирдагч	25	18000	450000
2	Ахлагч	25	18000	450000
3	Туслах ЭША	25	18000	450000
4	Туслах ЭША	25	18000	450000
5	Туслах ЭША	25	18000	450000
6	Туслах ажилтан	25	18000	450000
7	Туслах ажилтан	25	18000	450000
8	Туслах ажилтан	25	18000	450000
9	Туслах ажилтан	25	18000	450000
10	Туслах ажилтан	25	18000	450000
11	Туслах ажилтан	25	18000	450000
12	Тогооч	25	18000	450000
13	Туслах ажилтан	25	18000	450000
14	Туслах ажилтан	25	18000	450000
15	Жолооч	25	18000	450000
16	Жолооч	25	18000	450000
17	Жолооч	25	18000	450000
	Нийт			7650000

Жижиг хэрэглэлийн зардал

№	Утга	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Жижиг зай	1000	12	12000

Нийт зардал

№	Зардалын утга	Дүн
1	Томилолтын зардал	7650000
2	Сэлбэг	12000
	Нийт	7662000